## ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2023 ОНЫ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

**ХҮСНЭГТ 3.7**

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| **Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | | |
| 1.1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн | Төвийн хэмжээнд мөрдөн ажиллаж буй бодлогын баримт бичиг /төвийн эрхэм зорилго, алсын хараа, Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт/-үүд, түүнийг хэрэгжүүлэхээр хийгдэж буй үйл ажиллагаа, үр дүн, статистик мэдээллийг цаг тухай бүрт ЦССҮТ-ийн цахим хуудас-д байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилладаг.<br>Мөн төвийн I, II байранд нийт 8 мэдээллийн самбарыг байгууллагын брендбүүкийн дагуу хийж байршуулан, тушаал шийдвэр, үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллуулж байна.<br>2023 онд:<br>- Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого, зорилт, хамрах хүрээ /шинэчилсэн/<br>- Нэгдсэн менежментийн тогтолцооны чанарын гарын авлага /шинэчилсэн/<br>- Менежментийн тогтолцооны журмууд<br>- Эрхэм зорилго<br>- 1-12 саруудын статистик мэдээ<br>- Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт<br>- 2022 оны гүйцэтгэлийн хяналт үнэлгээний дүн, хавсралтыг байршуулсан.<br>- “Цусны донорын дэлхийн өдөр 2023”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө, удирдамж<br>- Цусны донорын Үндэсний өдөр тэмдэглэн өнгөрүүлэх удирдамж, тайлан<br><br>Доорх линкээс илүү дэлгэрэнгүй мэдээллийг харж болно. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Алсын хараа, Эрхэм зорилго https://donor.mohs.mn/web/?p=17<br>Сар, улирлын статистик мэдээ https://donor.mohs.mn/web/?p=6565<br>ЦССҮТ-ийн тайлан, төлөвлөгөө https://donor.mohs.mn/web/?p=6813 | |
| 1.2 | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг | • Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бүтэц, дүрмийг шинэчлэн батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 тушаал;<br>• Төвийн чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээ мэдээллийг төвийн ЦССҮТ цахим хуудас, Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт- болон Цус сэлбэлт судлалын үндэсний төв-Facebook- хуудсаар албан ёсоор мэдээлж, үйлчлүүлэгчийн хандалт болон мэдээ, мэдээллийн шинэчлэлийн байдалд жилд 1-2 удаа тогтмол дүн шинжилгээ хийн, хяналт тавьж ажиллаж байна.<br><br>Цус сэлбэлт судлалын салбараар үйлчлүүлсэн бүртгэлтэй нийт цусны донор үйлчлүүлэгчдийн **цусны бүлгийн мэдээллийг “E-Mongolia”** нэгдсэн системээр харах боломжтой ба 2023/01/01-2023/12/04 байдлаар давхардсан тоогоор нийт 71423 донор, үйлчлүүлэгч цусны бүлгийн мэдээллээ харсан байна.<br>“Цусны донор” аппликейшныг ашигласнаар донор хэдэн удаа цусаа өгсөн, хамгийн сүүлд хэзээ цусаа өгсөн, цус сэлбэлтээр дамжих халдвар илрүүлэх шинжилгээний хариуг харах, цусны бүлгийн мэдээлэл болон тэмдэглэлт өдрүүд, төвийн үйл ажиллагааны зарим мэдээллийг авах боломж бүрдсэн. Энэ нь донорын цагийг хэмнэж сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн.<br>Callpro: Нийт 3 дугаараар үйлчлүүлэгчдэд мэдээ, мэдээллийг тогтмол өгдөг ба 2023 онд нийт ирсэн дуудлага 4155 байна. **ЦССҮТ-ийн чатботын** 4 төрлийн цэснээс, 15 төрлийн үйлчилгээг авах боломжтой энэ нь үйлчлүүлэгчдийг цаг алдалгүй шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Chat bot: 2023 онд нийт 4,234 хэрэглэгч чат бот асуулгад хамрагдсан байна. Үүнээс 2,400 шинэ хэрэглэгч байна. | |
| 1.3 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Шинэчлэгдсэн шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд оруулах тус төвийн оруулах бүх төрлийн мэдээллийг, Төрийн аудитын fas.audit.mn цахим системд 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг байршуулсан. Тус төвийн ил тод нээлттэй байдлын самбарт тус тус байршуулсан.<br><br>Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт, мэдээллийн ил тод нээлттэй байдлын хэрэгжилт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, дотоод аудитын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн танилцуулга, Удирдлагын зөвлөлийн хурлын протокол, хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмж, ЭРүүл мэндийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын аудитын үнэлгээ, дүгнэлт зөвлөмжийг сайтад ил тод нээлттэй байршуулсан.<br><br>Төв нь үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001:2015, Лабораторийн чанар ба чадавхид тавигдах шаардлага ISO 15189:2015, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 45001:2018 стандартын хэрэгжилтэд тогтмол хөндлөнгийн болон дотоод аудитыг баталгаажуулах, магадлах чиглэлээр жил бүр зохион байгуулан аудитын тайланг ЦССҮТ цахим хуудаст байршуулан ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 1.4 | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан; | 2018 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан Донорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу хийж, гүйцэтгэсэн. Цусны донорын тухай хуулийн төсөл, үнэлгээний тайлан, бусад холбогдох материалыг dparliament.mn-д байршуулсан. | 100% |
| 1.5 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан; | Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг 2022 оны эцэст батлуулсан. Хөгжлийн хөтөлбөрийн 2023 оны арга хэмжээ, хөтөлбөрийг төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон алба, тасгийн төлөвлөвгөөнд тусган хэрэгжилтийг хангаж ажилласан. Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг УЗХ-д танилцуулж, нэмэлт өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэхээр бэлтгэж байна. Өмнөх хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг төвийн сайтад байршуулж ил тод нээлттэй байдлыг хангасан. | 100% |
| 1.6 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Тус төв нь:<br>• Монгол улсын хууль 28<br>• УИХ-ын тогтоол 3<br>• Ерөнхийлөгчийн зарлиг 2<br>• Засгийн газрын тогтоол 8<br>• Олон улсын болон үндэсний стандарт 14<br>• Засгийн газырн албан даалгавар 1<br>• Төрийн албаны зөвлөлийн зөвлөмж 1<br>• ЭМ-ийн сайдын тушаал 55<br>• Сангийн сайдын тушаал 2<br>• Хөдөлмөрийн сайдын тушаал 1 | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ● Ерөнхий захирлын 122 тушаал<br>● Ерөнхий журам 46<br>● Нэгдсэн лабораторийн журам 24<br>● Үйл явцын тодорхойлолт 9<br>● Стандарт ажиллагааны заавар 81<br>● Тоног төхөөрөмжийн ажлын заавар 39<br>● Ажлын заавар 60<br>● Маягт, бүртгэл 180<br>● Хяналтын хуудас 36-г үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн баримт бичгийн нэгдсэн жагсаалт гарган ажиллаж байна.<br><br>ЦССҮТ-ийн https://donor.mohs.mn/web/ вэб сайтын хууль эрхзүй цэсэнд үйл ажиллагаандаа мөрдөж буй<br>Хуульhttps://donor.mohs.mn/web/?p=569<br>Монгол улсын их хурлын тогтоол<br>Эрүүл мэндийн сайдын тушаалhttps://donor.mohs.mn/web/?p=578<br>Албан даалгавар<br>Ерөнхий захирлын тушаалыг байрлуулан тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>2023 онд дараах эрх зүйн актыг шинээр байршуулсан байна.<br>● ЭМС-ын 2023 оны А/67 "Эмийн гаж нөлөөг бүртгэх мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам" тус тус байршуулсан. | |
| 1.7 | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эхийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг; | ЦССҮТ-ийн Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт-н хүрээнд 9 алба, тасгийн 35 албан тушаалын тодорхойлолтыг https://donor.mohs.mn/web/ веб сайтын ил тод байдал цэсэнд https://donor.mohs.mn/web/?p=7022\ байршуулан, нийт 26 ажилтан /алба, тасгийн дарга эрхлэгч, эмч мэргэжилтнүүд/-ы эцэг /эхийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг төвийн https://donor.mohs.mn/web/ вэб сайтны танилцуулга цэсэнд ЦССҮТ-ийн алба хаагчдын мэдээлэл https://donor.mohs.mn/web/?p=6971 хаягтайгаар байршуулан тогтмол хяналт тавин ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 1.8 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Төвийн Ерөнхий захирлын 2022 оны 01 сарын 07-ны А/03 дугаар тушаалаар Үйлчилгээний санал, өргөдөл, гомдлыг шалган бүртгэх багийг томилон, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ вэб сайтын ил тод байдал цэсний Санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлэсэн байдал-д дараах мэдээллийг байршуулан тогтмол хяналт тавин ажиллаж байна. 2023 оны өргөдөл гомдол шийдвэрлэлтийн тайланг тухай бүр хугацаанд нь албан бичгээр хүргүүлсэн.<br>- Үйлчилгээний санал, өргөдөл, гомдлыг шалган бүртгэх баг шинэчлэн байгуулах тухай Ерөнхий захирлын А/03 дугаар тушаал<br>- Иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх Штаб байгуулах тухай Ерөнхий захирлын А/88 дугаар тушаал<br>- Донор, үйлчлүүлэгчдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь<br>- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, улирал тутам /2016-2023 он/ | 100% |
| 1.9 | Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | - Үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудас, вэб сайтад сар бүр тогтмол байршуулдаг. 2022 оны 1-12 сарын статистик үзүүлэлтийг доорх линкээр харах боломжтой. https://donor.mohs.mn/web/?p=6445<br>- Цусны албаны сүүлийн 5 жилийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэн баяжуулж “Эрүүл мэндийн үзүүлэлт 2022” эмхэтгэлд 2022 оны онцлох үйл ажиллагааны хамт хэвлүүлсэн.<br>- Цусны албаны үйл ажиллагааны статистик үзүүлэлтийн 2013-2022 оны дэлгэрэнгүй нэгтгэл гаргаж, мэдээний бүртгэлийн санг баяжуулсан. 2023 онд сарын бүрийн статистик мэдээг гарган, дүн шинжилгээ хийж, ажиллагсад болон удирдлагыг мэдээллээр тогтмол хангасан. Өдөр тутмын статистик тоон мэдээ гаргаж төвийн дотоод группэд байршуулж мэдээллийн шуурхай ил тод байдлыг хангаж, шийдвэр гаргах боломжоор бүрэн хангасан. | 100%<br><br>- |

| | | | |
|---|---|---|---|
| | | - Уламжлал болгон зохион байгуулладаг эрдэм шинжилгээний XX бага хуралд "ЦССҮТ-ийн цус цусан бүтээгдэхүүний зардлыг тооцсон дүн" Цусны албаны 2013-2022 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлийг харьцуулсан судалгаа сэдвээр хамтарсан илтгэл хэлэлцүүлсэн. Нийтэд мэдээллийн ил тод байдлыг хангаж https://donor.mohs.mn/web/?p=6565 хаягт тотмол байршуулсан. | |
| 1.10 | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр. | Зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг ЦССҮТ-ийн цахим хуудас, Цус сэлбэлт судлалын үндэсний төв-Facebook хуудсанд тогтмол байршуулдаг.<br><br>Үйл ажиллагааны онцлогтой холбоотой дараах олон нийтийг хамарсан үйл ажиллагааг жил бүр тогтмол зохион байгуулж олон нийтэд ил тод мэдээллэн ажиллаж байна.<br><br>Үүнд:<br><br>-Төвийн санаачлагаар жил бүрийн 1 дүгээр сарын 3-ныг "Цусаа бэлэглэх үндэсний өдөр" болгон тэмдэглэж, ард, иргэдийг цусаа бэлэглэх донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон нийтэд алдаршуулах арга хэмжээг зохион байгуулдаг. 2023 оны Цусаа бэлэглэх Үндэсний өдрийн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулж мэдээллийг ЦССҮТ-ийн цахим хуудас, Цус сэлбэлт судлалын үндэсний төв - Facebook зэрэг сошиал орчинд болон хэвлэл мэдээллийн байгууллагаар түгээж байршуулсан.<br>-Цусны донорын Дэлхийн өдөр"-ийн 20 дох удаагийн арга хэмжээг 2023 оны 06 сарын 14-ны өдөр "Тогтмол хугацаанд цус, сийвэнгээ өгч амьдрал бэлэглэе" уриа, ТОнор та амь тэтгэч сэдвийн дор ЭМЯ, ДЭМБ, МУЗН бусад байгууллага хамт олонтой хамтран орон даяар зохион байгуулж ЦССҮТ-ийн цахим хуудас, Цус сэлбэлт судлалын үндэсний төв - Facebook хуудсанд байршуулсан.<br>-Ард, иргэдийг донорын үйлсэд уриалан цусны донорын эгнээг өргөжүүлэх, байнгын донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчлах, олон | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | нийтэд алдаршуулахад зорилготой Сар бүрийн 3 “Цусаа бэлэглэх өдөр”-ийн 11 удаагийн арга хэмжээг Үйл ажиллагааг Сэтгэлийн 1000 үйлс ТББ, БЗД ИТХ, ЗДТГ, УЗДШХ, Барилгын хөгжлийн төв, МУЗН, УСУГ, Үнэртэй усанд дурлагсдын клуб, Улаанбаатар Смарт карт ХХК, МДХ, Сайн дурынхан хамтран зохион байгуулж, ULKER Mongolia, ТМВ ХХК брэнд МУЗН, Наран Бьюти ворлд, МДХ, МУЗН ХЗХГ зэрэг байгуулагатай хамтран зохион байгуулжээ.Сар бүрийн 3-ны өдрөөр үйлчлүүлэгчийн ЭМ-ийн боловсролыг дээшлүүлэх сургалт 2 удаа, “Хувь хүний хөгжил”-эрүүл ажлын байр” сэвдээр 1 удаа сургалт зохион байгуулсан байна. Цусны донорын тухай ерөнхий ойлголтыг танхимаар 2200 гаруй хүнд хүргэсэн. Нийт давхардсан тоогоор 60 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж донорын үйлсийн талаар мэдээлэл-50 ярилцлага -19, сурвалжлага, нийтлэл-15 удаа явуулж сурталчилгаа мэдээлэл хийсэн. хамтран зохион байгуулж ЦССҮТ-ийн цахим хуудас, Цус сэлбэлт судлалын үндэсний төв - Facebook хуудсанд байршуулсан.<br><br>- Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Амьдрал бэлэглэе пейж хуудас Донор та баатар групп хуудсанд донор алдаршуулах, Цусаа бэлэглэх өдрийг угтсан эвэнт, мэдээлэл байршуулж олон нийтэд хүргэж, цусны донорыг алдаршуулсан.<br><br>- ЭМЯ, НЭМҮТ-өөс гаргасан В гепатит, Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, Халтиргаа гулгаанаас сэргийлэх, Сэтгэцийн эрүүл мэндийн заавар зөвлөмжүүдийг тогтмол төвийн цахим хуудас ашиглан ажиллагсад, ард иргэд, цусны доноруудад хүргэж хэвшсэн. | |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |
| **Хоёр. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | | |
| 2.1 | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл | Сул ажлын байранд Сонгон шалгаруулалт явуулах зарыг Зангиа.мн сайт, ЭМХТ-ийн HRDC систем, Төвийн вэб сайтад | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | https://donor.mohs.mn/web/?p=1357 тус тус тухай бүр ил тод байрлуулан ажиллаж байна. 2023 онд Нийт 23 ажилтан ажилд орсноос:<br>Жирэмсэний болон амаржсаны чөлөөтэй ажилтны оронд -4<br>Түр ажлын байранд -2<br>Байнгын ажлын байранд -17 албан хаагч томилогдсон байна.<br>2023 оны жилийн эцсийн байдлаар Захиргаа, маркетингийн албанд-1, Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албанд-1, Сувилахуй, үйлчилгээний албанд-1, Үйлдвэрлэлийн тасагт-1, Нэгдсэн лабораторийн тасагт-1 /ХАЧ-тэй хүний орлонд түр/ сул ажлын байр байгааг ЭМХТ-ийн HRDC болон төвийн вэб сайтад ил тод байрлуулан ажиллаж байна.<br><br> | |

| | | | |
|---|---|---|---|
| | |  | |
| 2.2 | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | ЦССҮТ-ийн “Сонгон шалгаруулалтын журам”-ыг шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Шинээр томилогдсон ажилтныг төвийн “Дасан зохицох хөтөлбөрийн журам”-д заасны дагуу Чиглүүлэх сургалтад хамруулан, жинхлэн томилох асуудлыг шийдвэрлэж байна.<br><br>Дээрх журмыг ЦССҮТ-ийн цахим хуудасны ил тод байдал цэсэнд https://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2022/11/Songon-shalgaruulaltiin-21022.pdf байршуулсан.<br><br>    | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3 | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм | ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ вэб сайтын Ёс зүйн салбар хороо цэсэнд албан хаагчийн ёс зүйн дүрэм https://donor.mohs.mn/web/?p=4709 байршуулахаас гадна Төвийн ёс зүйн салбар хорооны самбарт дараах мэдээллийг байршуулан ил тод байдлыг ханган ажиллаж байна.<br><br>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм 2019 оны 406 тоот тушаал<br>Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл<br>Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм 2019 оны Засгийн газрын 33 тогтоол<br>Төвийн мөрдөж ажиллах зарчим<br>Эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн тулгуур зарчим<br><br>"Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" багц цагийн цахим сургалтанд /ЭМХТ-ийн HRDS/ 2022.09.16-нд АШУҮИС-Эрдмийн сургуулиас 1 багц цагийн кредиттэй Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалтад нийт 36 ажилтан хамрагдсан.<br>Ажилтаны ёс зүй харилцаа, хандлагыг асуумжаар авч, нэгтгэн дүгнэхэд:<br>Эмнэлгийн үйлчлүүлэгч: ЦЦБ-ний түгээх хэсгийн үйлчилгээний ажилтаны харилцаа, хандлага, ёс зүй 98% маш сайн, сайн, дунд 1%, муу 1% гэж үнэлсэн<br>Донор үйлчлүүлэгч: Мэргэжилтний үйлчлүүлэгчтэй харилцах ёс зүй сайн 78%, дунд 20,5%, хангалтгүй 1,5%<br>Төвийн ажилчдын үнэлгээ: Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сайн 80,4%, дунд 19,6 үнэлсэн байна. Эрүүл мэндийн байгууллагын ажилтны ёс зүйн сайн 74,9%, дунд 25,1% гэж үнэлсэн байна.<br>Донор үйлчлүүлэгч, эмнэлгийн үйлчлүүлэгч, төвийн ажилчидаас сэтгэл ханамжийн судалгааг (docs.google.com) авч, нэгтгэсэн, үүнд:<br>Нийт 3 удаа 308 донор, үйлчлүүлэгчээс авсан үүнд: Ерөнхий сэтгэл ханамж маш сайн 82,6%, дунд 16.3, муу 1, 2 байна% гэж үнэлсэн байна<br>ЦЦБ-ийг хэрэглэгч эмнэлгийн 82 мэргэжилтнээс авсан сэтгэл ханамж судалгаа асуумжаар авч, нэгтгэн дүгнэхэд: Ерөнхий сэтгэл ханамж маш сайн 59%, сайн 40%, муу 1% гэж үнэлсэн байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | Төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнаас 2 удаа давхардсан тоогоор 106 асуумж авснаас, Ерөнхий сэтгэл ханамж 78,6% байна.<br>Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, танилцуулсан.<br>ЁЗСХ тайланг хагас жил, бүтэн жилээр ЭМЯ ЁЗХХ илгээсэн. | |
| 2.4 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам | Хүний нөөцийн хөгжлийг хангах 2023 оны төлөвлөгөөний биелэлт 100% хэрэгжсэн байна. Байгууллагын хүний нөөцийн бүрдүүлэлтийг 98-100% байлгаж, холбогдох сонгон шалгаруулалтын дүнд үндэслэн мэргэшсэн хүний нөөцөөр нөхөн хангахад анхааран ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн хууль /шинэчилсэн найруулга/-тай уялдсан Хамтын гэрээ байгуулан бүртгүүлж, Хөдөлмөрийн дотоод журам, түүнтэй уялдан гарах<br>Сонгон шалгаруулалтын журам,<br>Хүний нөөцийн төлөвлөлтийн журам,<br>Дасан зохицох хөтөлбөрийн журам,<br>ЦССҮТ-ийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр, төлөвлөгөө,<br>Мөнгөн урамшууллын журам,<br>Сургалт хөгжлийн журам,<br>Цалин хөлсний журам, Шагнал урамшуулын журмыг тус тус батлуулан, Ур чадварын нэмэгдэл олгох журамын төсөл боловсруулан ҮЭСХ, Алба, тасгийн саналыг авч нэгтгэн Ажлын хэсгийн хурлаар хэлэлцээд байна.<br><br>Төвийн ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ вэб сайтын ил тод байдал цэсний хүний нөөцийн удирдлагын ил тод байдал хэсэгт https://donor.mohs.mn/web/?p=4714, https://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2022/11/Dasan-zohitsoh2022.pdf дээрх журам, хөтөлбөрүүдийг байршуулсан. | 100% |
| 2.5 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр Хүний нөөцийн төлөвлөлтийн, Сонгон шалгаруулалтын, Дасан зохицох хөтөлбөрийн журам, | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | ЦССҮТ-ийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр, төлөвлөгөө батлан байгууллагын вэб хуудсанд ил тод байршуулж байна.<br><br>Төвийн https://donor.mohs.mn/web/?p=4714 вэб сайтад байршуулсан<br><br>https://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2022/11/Dasan-zohitsoh2022.pdf -д байршуулсан<br><br>    | |
| 2.6 | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх зорилгоор Төвийн “Мөнгөн урамшууллын журам”, “Цалин хөлсний журам”-ыг шинэчлэн батлуулж, Засгийн газрын тогтоол шийдвэрийг баримтлан Ажилтнуудын улирлын ажлын | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | үр дүнгээр олгох урамшуулал, ур чадварын нэмэгдлийг холбогдох алба, тасгийн дарга, эрхлэгч, ажилтны санал, шийдвэрийг тусгах замаар ил тод хэрэгжүүлсэн.<br><br>Дээрх журмыг ЦССҮТ-ийн цахим хуудасны https://donor.mohs.mn/web/-ны Ил тод байдал цэсэнд https://donor.mohs.mn/web/?p=4714 , https://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2022/11/mongon-uramshuulal.pdf -д тус тус байршуулсан | |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |
| **Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх** | | | |
| 3.1 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийн аудитлагдсан тайланг Шилэн дансны цахим систем болон, Сангийн Яамны Э-тайлан цахим системд оруулж, ЭМЯ, СЯ-ны нэгдсэн санхүүгийн тайланд нэгтгэгдсэн. Тайлант оны төсвийн хуваарийг шилэн дансаны цахим системд ил тодоор байршуулсан. 2022 оны 7 сард байгууллагын 2023 оны төсвийн төсөл, хөрөнгө оруулалтын саналыг ЭМЯ-нд хүргүүлсэн. 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын стратеги төлөвлөлтөд тусгагдсан арга хэмжээнүүдийг оруулан төлөвлөсөн. 2023 оны төсвийн төсөлд нийт 12.5 тэрбум төгрөгийн саналыг тусгаж хүргүүлсэн. 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2023 оны батлагдсан төсөв, 2024 оны төсвийн төсөл, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлүүдийг цаг тухай бүр нь Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим систем, ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/, байгууллагын ил тодын самбарт тус тус байршуулсан. | 100% |
| 3.2 | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг сар бүр ЭМЯ-ны төрийн санд өгч, шилэн дансны цахим системд тоон мэдээллээ оруулж, баталгаажсан тайланг скайнердаж хавсралтаар оруулж байна. 2023 оны эхний хагас жилийн | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | | санхүүгийн тайланг Э-Тайлан цахим системд оруулж, ЭМЯ баталгаажуулан хүлээн авсан, мөн Шилэн данс (shilendans.gov.mn) шилэн дансны цахим системд хугацаанд нь байршуулсан. | |
| 3.3 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | ЦССҮТ-ийн 2022 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд болон, байгууллагын ил тодын самбарт байршуулсан. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллага материаллаг томоохон хэмжээний алдаагүй, үнэн зөв толилуулсан гэж үзэж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн. | 100% |
| 3.4 | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ | 2023 оны 10 сараас цэвэр бохир усны төлбөрт өөрчлөлт орсоны дагуу төлбөрийн нэхэмжлэл ирж байна. Тус төвөөс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээ, бүтээгдэхүүний төлбөрт 2022 онд өөрчлөлт орсоныг ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд байршуулсан. 2023 оны мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 3.5 | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар | Төсвийн хэмнэлтийн тухай хуулитай уялдуулан зардлыг аль болох хэмнэлттэй зарцуулж, дутагдаж байгаа үндсэн үйл ажиллагааны зардалд гүйлгэн зарцуулж ажиллаж байна. ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд болон, байгууллагын ил тодын самбарт байршуулсан. | 100% |
| 3.6 | Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; | ТБОНӨТ хуулийн босго үнийн болзлыг хангасан худалдан авч байгаа бараа ажил үйлчилгээнд тендер шалгаруулалт явуулж, гэрээ байгуулан зарцуулалтыг гаргаж байгаа ба Таван сая төгрөгөөс дээш босго үнээс доош худалдан авалтанд гэрээ байгуулан ил тод мэдээллийг ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ Шилэн дансны https://shilendans.gov.mn/org/1296 цахим системд болон, байгууллагын ил тодын самбарт байршуулан ажиллаж байна. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.7 | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт шилэн дансанд байршуулдаг. Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд болон байгууллагын ил тодын самбарт байршуулсан. | 100% |
| 3.8 | бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | ЦССҮТ-тэй холбогдолтой мөнгө захиран зарцуулж байгаа тушаал шийдвэр, өр авлага үүсгэхтэй холбоотой үйл ажиллагааны холбогдолтой гэрээг цахим хуудас https://donor.mohs.mn/web/ Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд байршуулсан. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.9 | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийг шилэн дансанд мэдээлсэн. ЦССҮТ-ийн ил тод байдлын мэдээллийн самбарт, Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд болон, байгууллагын ил тодын самбарт байршуулсан. 2023 оны 01 сарын 01-нээс эхлэн шинэ шилэн дансны системд мэдээллийг оруулан ажиллаж байгаа бөгөөд 2023 онд нийт 163 мэдээлэл оруулахаас 141 нэр төрлийн мэдээллийг хугацаанд нь оруулж, 2 мэдээллийг хугацаа хоцроосон, 20 мэдээлэл оруулах хугацаа болоогүй байна. Үлдсэн мэдээллийг хугацаа хоцроохгүйгээр мэдээллэхээр ажиллаж байна.<br><br>Хоцорсон мэдээллээс Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан нь төрийн аудитийн тухай шинэчлэгдсэн хуулийн дагуу сар бүрийн 9 сарын 1-ны дотор биелэлтийг гаргах боломжтой байдаг. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 3.10 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг 2023 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу цахимаар зохион байгуулсан. Худалдан авах ажиллагааны Худалдан авах амжиллагааг цахимаар зохион байгуулж tender.gov.mn сайтад тухай бүр мэдээллийг оруулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг https://donor.mohs.mn/web/?p=6808 , урилгыг https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1645951178164 холбоосоор үзэж болно. Шилэн дансны https://shilendans.gov.mn/org/1296 цахим системд болон, байгууллагын ил тодын самбарт байршуулсан. | 100% |
| 3.11 | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; | Төвийн 2022 оны Үндэсний аудитын газраас гэрээ байгуулан сонгогдсон хөндлөнгийн аудитын худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд өгсөн дүгнэлтэд нэг зөвлөмж тусгасан бөгөөд бид 2023 оны худалдан авах ажиллагаанд зөвлөмжийг хэрэгжүүлж, залруулан, худалдан авах ажиллагааг үнэлэн ажилласан ба бид “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хэрэгжилтэнд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд тендерийн үнэлгээний хороонд хөндлөнгийн 2-оос доошгүй гишүүний оролцуулан зохион байгуулж хэвшсэн болно. ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ байршуулсан | 100% |
| 3.12 | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Тус төвийн чиг үүрэгт хамааралгүй болно. | |

| | | | |
|---|---|---|---|
| 3.13 | Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн | 2023 онд Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна. | |
| 3.14 | Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан; | 2023 онд Мэдээлэл хариуцагчийн захиалгаар судалгаа, шинжилгээний ажил хийгдээгүй байна. | |
| 3.15 | Хууль тогтоомжид заасан бусад. | ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын нийтийн мэдээлийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн хамаарал бүхий шийдвэрийг donor.mohs.mn цахим хуудсанд байршуулж ажилласан.<br>Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг тухай бүр цахим хуудсанд бүртгэж ажилласан бөгөөд 2023 онд 96 мэдэгдэл бүртгэсэн байна.<br> | 100% |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |

| Дөрөв.Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн | | | |
|---|---|---|---|
| 4.1 | Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ вэб сайтад ЭМС-ын 2022 оны А/117 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн ЭМБ-аас бусад эрүүл мэндийн байгууллага, ААНБ болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтад 17 тусламж, үйлчилгээний жагсаалтыг болон Шилэн дансны Шилэн данс (shilendans.gov.mn) цахим системд Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 49/А/118 дугаар тушаалаар баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн ЭМБ-аас бусад эрүүл мэндийн байгууллага, ААНБ болон иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний үнэ тарифыг байршуулсан бөгөөд тус төвийн үйл ажиллагаанд мөрдөгдөх жагсаалтыг ерөнхий захирлын тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна.<br><br>https://donor.mohs.mn/web/wp-content/uploads/2017/01/Une-2022.pdf | 100% |
| 4.2 | тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа. | Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно. Төв өөрийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулахад шаардлагатай материалыг жагсаалтын дагуу бүрдүүлж албан бичгийн хамт хүргүүлсэн болно. | |
| Хэсгийн дундаж хувь: | | | 100% |
| Тав.Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал | | | |

| | | | |
|---|---|---|---|
| 5.1 | Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, | 2023 оны 12 дугаар сард УИХ-д өргөн баригдахаар төлөвлөгдсөн Цусны донорын тухай хуулийн төслийг холбогдох материалын хамт https://d.parliament.mn/tusul/5ddac356-2f3e-4322-a378-03cd56b57d3b байршуулж санал авсан.<br><br>- "Зонхилон тохиолдох өвчний үед цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх заавар" Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/03 шинэчлэн боловсруулах ажлын хэсэг тушаалын төсөл<br>- Донорт эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөнгөлөлттэй үзүүлэх, эрүүл мэндийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулах тухай Эрүүл мэнд спортын сайдын 2015 оны А/194 дугаар тушаал,<br>- "Цусны хүндэт донорыг сувилуулах тухай" Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/43 дугаар тушаалыг шинэчлэх журмын төслүүдэд байгууллага ажлын хэсэг байгуулах, удирдлагын багаар ярилцах, хамт олонд мэдээллэж санал авах байдлаар ил тод нээлттэй байдлыг хангаж хамтарч ажилласан. | 100% |
| 5.2 | Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт; | Монгол улсын Оюуны өмч, улсын бүртгэлд төвийн бэлгэ тэмдэг Дорго, цусны донор алдаршуулалтын тэмдэг, сар бүрийн 3 цусаа бэлэглэх өдрийн лого зэрэг барааны тэмдгийг 2027 он хүртэл 10 жилийн хугацаатай бүртгүүлж эзэмшиж байна.<br><br>ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ вэб сайтад байршуулсан https://donor.mohs.mn/web/?p=6880 | 100% |
| 5.3 | Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл; | Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно. | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5.4 | мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Төвийн 1, 2-р байрны газрын гэрчилгээ, хуулийн этгээдийн газар эзэмших гэрээг бар коджуулахад шаардагдах материалыг бүрдүүлж Нийслэлийн өмчийн харилцааны газраас төвийн I байрны газрын гэрчилгээг бар коджуулан мэдээллийн санд оруулсан. Төвийн II байрны газар ЭМЯ-ны нэр дээр байгаа тул ЭМЯ-д олгосон. ЭМЯ-нд газар шилжүүлэх асуудлаар бичгээр болон утсаар төвийн хүсэлтээ тавьсан шийдвэрлээгүй. Тус төвийн 1, 2-р байрны газар эзэмших эрхийн гэрчилгээг ЦССҮТ-ийн цахим хуудас https://donor.mohs.mn/web/ вэб сайтад байршуулан ил тод байдлыг хангаж байна. | 100% |
| 5.5 | төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл. эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг; | Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно. | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5.6 | төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл; | Тус төв нь гүйцэтгэлийн санхүүжилтэд шилжээгүй, даатгалд хамрагдаагүй, төсвийн санхүүжилттэй байгууллага. Байгууллагын удирдлага, ажилтан төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүнд ажилладаггүй. | |
| 5.7 | төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл; | Төвийн 1 дүгээр байрны 2ш автозогсоолыг талбайг холбогдох тогтоол шийдвэрийн дагуу ЭМЯ-ны харъяа байгууллага Эмгэг судлалын үндэсний төвийн 2 автомашиныг тавиулж түрээсийн 40 хувийг ТӨБЗГ-ын дансанд бүрэн төвлөрүүлж тооцоо нийлсэн. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| 5.8 | Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл; | 2023 оны 12 дугаар сард УИХ-д өргөн баригдахаар төлөвлөгдөж буй Цусны донорын тухай хуулийн төслийг боловсруулах явцад төвийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаар дүн шинжилгээ хийж, 2022 оны 7 дугаар сарын 7-ны өдөр d.parliament.mn вэб сайтад байршуулсан. Доорх линкээр дэлгэрэнгүй мэдээллийг харж болно.<br>https://d.parliament.mn/tusul/5ddac356-2f3e-4322-a378-03cd56b57d3b | 100% |
| 5.9 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт | Төвийн 1-р байрыг 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын 2016/143 дугаар актаар ашиглалтад хүлээн авсан. Барилга ашиглалтад оруулах актыг төвийн вэйб сайтад байршуулж ил тод байдлыг хангасан. | 100% |
| 5.10 | Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ; | Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно. | - |
| 5.11 | нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл | Төвийн чиг үүрэгт хамаарахгүй болно. | |

| | | | |
|---|---|---|---|
| 5.12 | Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эхийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт | 2023 онд Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцсан ажилтан байхгүй байна. | |
| 5.13 | Хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. | Төвийн чиг үүрэгтэй холбоотой хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл байхгүй болно. | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ДАРГА Ч.БАТБОЛД

ХЯНАСАН:
ДОТООД АУДИТОР С.АЛТАННАМАР